

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 01-ны өдөр

№ 12

Улаанбаатар хот

**“Эрсдэлийн удирдлагын бодлого”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох хэсгүүдийг үндэслэн **ТОГТООХ** нь:

- “Сэндли ББСБ” ХК-ийн “Эрсдэлийн удирдлагын бодлого”-д хавсралт ёсоор нэмэлт, өөрчлөлт оруулсугай.
- Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн холбогдох хороодод, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ





## “ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО”-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1. Эрсдэлийн удирдлагын бодлогод доор дурдсан агуулгатай заалт, бүлгийг шинээр нэмсүгэй.
  - 1.1. Бодлогын 1.4.13 дахь заалтад **Мэдээллийн аюулгүй байдал**- БСБ-ын мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдал хангагдсан байхыг;
  - 1.2. Бодлогын 3.1.8 дахь заалтад **Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл** – Байгууллагын бүх төрлийн мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх, ашиглах, задруулах, тасалдуулах, өөрчлөх, устгах зэргээс үүдэн гарч болзошгүй аюул хохирол эрсдэлийг хэлнэ.
  - 1.3. Бодлогын 3.1.9 дэхь заалтад **Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэл**- байгаль орчны хүчин зүйлс, уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн харилцаа, компанийн засаглалын асуудлаас үүдэн гарч болзошгүй аюул хохирол эрсдэлийг хэлнэ.
  - 1.4. *Арван нэгдүгээр зүйл. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл*
    - 11.1 Мэдээлэл, мэдээллийн нууцлал болон мэдээлэл хадгалах, дамжуулах технологийг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг тооцож үнэлгээ хийнэ.
    - 11.2 Сүлжээ, сүлжээнд холбогдох тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангана.
    - 11.3 Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг журмаар зохицуулна.
    - 11.4 Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг бэлтгэл, эрсдэл тооцоолох, эрсдэлийн түвшинг үнэлэх, эрсдэлийг бууруулах зөвлөмж гаргах гэсэн дөрвөн үе шатаар хийж гүйцэтгэнэ.
    - 11.5 Эрсдэлийн үнэлгээг аюулын нөлөө, аюулын магадал, эмзэг сул байдлыг харгалзан тодорхойлно.
    - 11.6 Эрсдэлийн түвшинг бага, дунд, дундаас дээш, өндөр, хэт их гэсэн 5 түвшингээр тодорхойлно.
    - 11.7 Эрсдэлийн түвшин бүрд тохирох хүлээн зөвшөөрөх, хуваалцах, шилжүүлэх, зайлсхийх арга хэмжээг авч ажиллана.
- 1.5. *Арван хоёрдугаар зүйл. Байгаль орчин, нийгэм засаглалын эрсдэл*
  - 12.1 Байгаль орчны, нийгмийн, засаглалын эрсдэлийн удирдлагын үе шат
    - 12.1.1 Байгаль орчны, нийгмийн, засаглалын эрсдэл тодорхойлох
      - 12.1.1.1 БСБ-ын үл ажиллагаанд хамааралтай байгаль орчин, нийгэм, засаглалын хүчин зүйлсийн талаар шинжилгээ хийж, эрсдэлийг тодорхойлно.
      - 12.1.1.2 Байгаль орчны, нийгмийн, засаглалын эрсдэл үнэлэх
      - 12.1.1.3 Байгаль орчин, нийгэм, засаглалын хүчин зүйлийн эрсдэлийг тодорхойлоод тэдгээрийн ач холбогдол, үүсэх магадлалыг үнэлнэ.
    - 12.1.2 Байгаль орчны, нийгмийн, засаглалын эрсдэл бууруулах
      - 12.1.2.1 Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийг үнэлсний үндсэн дээр эрсдэлийг бууруулах стратеги боловсруулна.
  - 12.1.3 Байгаль орчны, нийгмийн, засаглалын эрсдэл бууруулах стратегийн хэрэгжилтийг үнэлж, биелэлтэнд хяналт тавина.

- 12.2 Байгаль орчны, нийгмийн, засаглалын эрсдэлийн хамрах хүрээ
- 12.2.1 Байгаль орчин
- 12.2.1.1 Эрчим хүчний хэрэглээ болон хэмнэлт  
12.2.1.2 Хүлэмжийн хийн ялгарал  
12.2.1.3 Уур амьсгалын өөрчлөлт  
12.2.1.4 Усны удирдлага  
12.2.1.5 Хог хаягдал  
12.2.1.6 Биологийн олон янз байдал
- 12.2.2 Нийгэм
- 12.2.2.1 Хүний нөөцийн хөгжил  
12.2.2.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй  
12.2.2.3 Эрх тэгш байдал  
12.2.2.4 Хүртээмжтэй орчин, оролцоо  
12.2.2.5 Нийгмийн хариуцлага, ил тод байдал  
12.2.2.6 Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлага
- 12.2.3 Засаглал
- 12.2.3.1 Авлига, ёс зүй  
12.2.3.2 Компанийн засаглал  
12.2.3.3 Хууль эрх зүйтэй холбоотой  
12.2.3.4 Комплайнс  
12.2.3.5 Хувьцаа эзэмшигчдийн оролцоо
2. Эрсдэлийн удирдлагын бодлогод дараах өөрчлөлтүүдийг оруулсугай.
- 2.1. Бодлогын 7 дугаар зүйлийн 7.7.1, 7.7.2 болон 13 дугаар зүйлийн 13.2-т заасан “эрсдэлийн удирдлагын хороо” гэснийг “аудит, эрсдэлийн удирдлагын хороо” гэж өөрчилсүгэй.
- 2.2. Бодлогын Арван нэгдүгээр зүйлийг Арван гуравдугаар зүйл, Арван хоёрдугаар зүйлийг Арван дөрөвдүгээр зүйл болгон өөрчилсүгэй.